



Оюутны програмчлалын үндэсний XIII олимпиадыг зохион явуулах тухай

Оюутны програмчлалын үндэсний олимпиадыг манай сургууль 2009 оноос эхлэн Олон улсын оюутны програмчлалын Азийн бүсийн олимпиадыг зохион байгуулах хорооны ивээл дор жил бүр эх орондоо 12 удаа амжилттай зохион явуулж ирсэн.

Энэ удаагийн 13-р олимпиадыг 2023 оны 05-р сарын 20-ны өдөр МУИС дээр зохион явуулахаар ажиллаж байна. Олимпиадын үндсэн зорилго нь оюутнуудын програмчлалын ур чадварыг хөгжүүлэх, Ази тивийн 47-р олимпиадад оролцох Монгол улсын багийг шалгаруулах явдал болно.

Иймд та бүхнийг өөрийн сургуулийн оюутны багийг бэлтгэн уг олимпиадад идэвхтэй оролцохыг урьж байна.

Хавсралт 1. Оюутны програмчлалын үндэсний XIII олимпиадын удирдамж

1. Олимпиадыг олон улсын оюутны програмчлалын (АСМ ICPC) олимпиадын дүрмийн дагуу зохион байгуулна. Дэлхийн ба бүсийн тэмцээний дүрмийг <http://icpc.global/> хаягаас, Зохион байгуулалтын журмыг хавсралт 2-оос, нэмэлт мэдээллийг <http://seas.num.edu.mn/> хаягаас эсвэл 7730 7730-3114 (Зохион байгуулах комисс (Г.Багаболд 99230862, Д.Гармаа 91173161) утсаар авч болно.
2. Олимпиадын үйл ажиллагааг Програмчлалын үндэсний олимпиадыг зохион байгуулах комисс удирдан зохион байгуулж эцсийн шийдвэрүүдийг гаргана.
3. Зохион байгуулах комисс нь сургуулиудын саналыг үндэслэн бодлого сонгох ба зөвлөх комиссын бүрэлдэхүүнийг томилно.
4. Оролцогч сургууль болон хөгжүүлэгчдийн өөрийн багийн мэдүүлгийг 5-р сарын 17-ний дотор цахимаар бүртгүүлнэ.
5. Бүртгэлийн хугацаанаас хоцорсон багийг олимпиадад оролцуулахгүй.
6. Олимпиадад оролцох баг бүр 50.000 төгрөгийн хураамж төлнө. Хураамжийг бэлнээр төлж эсвэл дансаар шилжүүлж болно. Дансны дугаар: Голомт банк: 8115006179, Хаан банк: 5041339528, Хүлээн авагч: МУИС, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль. Гүйлгээний утга: Сургуулийн нэр, багийн нэр, Програмчлалын үндэсний олимпиадын хураамж
7. Олимпиадад дэвшүүлэх бодлогыг 05 сарын 18-ны өдрийн 18:00 цагаар өмнө bagabold@seas.num.edu.mn цахим хаяг руу илгээнэ.
8. Оролцох багууд 2-3 минутын видео танилцуулга хийж комиссын tsetsegjargal@seas.num.edu.mn цахим хаяг руу илгээнэ.
9. Техникийн зөвлөлгөөн 5-р сарын 08-ны өдрийн 17:00 цагт МУИС-ийн хичээлийн 3-р байрны 217 тоот өрөөнд болно.
10. 5-р сарын 19-ны өдрийн 16 цагаас Бэлтгэл тэмцээнийг МУИС-ийн хичээлийн 3-р байрны 215, 222, 227 тоот өрөөнд явуулна.
11. Тэмцээний нээлт 5-р сарын 20 өдрийн 10 цагаас МУИС-ийн хичээлийн 1-р байрны 320 тоот танхимд болно. Үндсэн тэмцээн 5-р сарын 20-ны өдрийн 12:00 - 17:00 цагийн хооронд 5 цагийн хугацаанд Хичээлийн 3-р байрны 215, 222, 227 тоот лабораториудад явагдана.
12. Тэмцээний дараа бодлогын шинжилгээ, ярилцлага.
13. Олимпиадын дүнгийн хурал 5-р сарын 22-ний өдрийн 16:00 цагаас МУИС-ийн хичээлийн 1-р байрны Дугуй танхимд болно.

Хавсралт 2. Олимпиадын зохион байгуулалтын журам

1. Энэ олимпиад нь багийн тэмцээн байна.
2. Сургууль/факультет бүрийн баг нь Хавсралт 6-д (<http://cm.baylor.edu/>) заасан болзолыг хангасан 3 оюутнаас бүрдэнэ. Багийн 3 гишүүн 1 компьютер дээр ажиллана. Баг нь 1 дасгалжуулагч багштай байна.
3. Нэг сургуулиас дээд тал нь 2 баг оролцож болно. Өнгөрсөн жилийн 12-р олимпиадад багууд нь эхний гурван байранд шалгарсан сургуулиуд нэмэлт 1 багийг оролцуулж болно.
4. Мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд нь өөрийн ажилтнуудын програмчлалын мэдлэг чадварыг сорих зорилгоор өөрийн багийг олимпиадад оролцуулж болно. Эдгээр “одтой” багуудын амжилтыг зөвхөн хувийн амжилт гэж үзэх бөгөөд сургуулиудын багийн шалгаруулалтад тооцохгүй.
5. Олимпиадын үргэлжлэх хамгийн их хугацаа 5 цаг байна.
6. Олимпиадыг олон улсын оюутны програмчлалын олимпиадын DomJudge системээр шүүнэ.
7. Эхний гурван байр эзэлсэн багийг алт, мөнгө, хүрэл медаль, МУИС-ийн болон ивээн тэтгэгч байгууллагуудын нэрэмжит шагналаар шагнаана.
8. Олимпиадтай холбоотой аливаа асуудлыг баг нь дасгалжуулагчаараа дамжуулан Зохион байгуулах комисст тавина.
9. Үндсэн тэмцээний үеэр бодлоготой холбоотой асуултуудыг тэмцээний эхний 2 цаг 30 минутын дотор л тавьж болно.
10. Тэмцээний үеэр Интернэтээс мэдээлэл хайх татаж авах, зөөврийн төхөөрөмж ашиглахыг бүрэн хориглоно. Хэрвээ иймэрхүү зөрчил гаргавал тухайн багийг тэмцээнээс чөлөөлөх бөгөөд тухайн багийн харъяалагдах сургуулийн багийг дараа жилийн олимпиадад оролцуулахгүй.
11. Үндсэн тэмцээний үеэр хэвлэмэл материал ашиглаж болох эсэх, ашиглах тохиолдолд ямар материал байхыг техникийн зөвлөгөөн дээр шийдэнэ.

Хавсралт 3. Багийн мэдүүлгийн хуудас

А. Багийн гишүүдийн мэдүүлэг

№	Овог, нэр	Төрсөн он, сар, өдөр	Тухайн сургуульд элссэн он	Одоо суралцаж байгаа мэргэжил	Програмчлах хэл	Имэйл хаяг, утас	Багийн товч нэр (англи цагаан толгойн үсгүүдээс бүрдсэн)
1.							
2.							
3.							

Б. Багийн дасгалжуулагчийн мэдүүлэг

№	Овог, нэр	Сургууль, тэнхим	Үндсэн мэргэжил	Холбоо барих утас	Имэйл хаяг
1.					

Хавсралт 4. Бодлого сонгох ба зөвлөх комиссын ажиллах журам

I. Ерөнхий зүйл

1. Комисст ажиллах гишүүд үнэнч шударга, ёс суртахуунтай, тухайн комисст ажиллах хүсэл эрмэлзэлтэй байна.
2. Комиссын гишүүд бусдыгаа хянах эрхтэй.
3. Комиссууд сондгой тооны гишүүдтэй байх бөгөөд гишүүд аливаа асуудлыг сайтар нухацтай ярилцаж олонхын саналаар шийдвэрлэнэ. Гишүүд ярилцаж зөвлөлдөхдөө бусдынхаа гаргаж байгаа саналыг хүндэтгэн сонсож алдаагүй ажиллахыг эрмэлзэх ёстой.
4. Нэг зохиогчийн 2-оос олон бодлогыг олимпиадын үндсэн бодлогод оруулахгүй

II. Бодлого сонгох комиссын ажиллах журам

1. Комисс дэвшигдсэн бодлогуудыг нарийн бичгийн даргаас хүлээн авч олимпиадад бодох бодлогын шаардлагыг хангасан бодлогуудыг ялгаж дараа нь тэдгээр бодлогуудаас олимпиадын бодлогуудыг сонгоно.
2. Шаардлагатай гэж үзвэл бодлогын зохиогчийг бодлого сонгох өрөөнд урин ирүүлж тайлбар авч болно.
3. Зохиогчийн бодолтыг шүүлтийн PC² систем дээр шалгана.
4. Комисс сонгогдсон бодлогуудыг багийн тоогоор хувилж нарийн бичгийн даргад хүлээлгэж өгнө.
5. Сонгогдсон бодлогуудын нууцыг тэмцээн дуустал хадгалж бодлогуудын үнэн зөв байдлыг хариуцна.

III. Зөвлөх комиссын ажиллах журам

1. Комиссын гишүүд тэмцээн дуусах хүртэл комиссын байранд байрлаж багуудаас тавьсан асуултад хариулна. Тухайн асуултуудад хариулахдаа хяналт тавих хүний хамт тэмцээн явагдаж буй байранд очиж хариултыг өгнө. Хариултыг аль болох товч, тодорхой байдлаар өгнө.
2. Тэмцээний өрөөнд ажиллах үедээ гар утас болон холбооны бусад төхөөрөмжүүдээ унтраасан байна.
3. Зөвлөх комисс нь тэмцээний урьдчилсан дүнг гаргаж хороонд өргөн барина.
4. Тэмцээн дууссаны дараа бодлогын анализыг хийнэ.

Хавсралт 5. Олимпиадын бодлогод тавигдах шаардлага

1. Бодлогын өгүүлбэр тодорхой, хоёрдмол утгагүй, ойлгомжтой байх
2. Бодлого нэг хариутай байх
3. Бодлогын оролт, гаралтыг нэг, нэг файлд байрласан байхаар зохион байгуулна. Оролт нь олон сонголттой байна.

Дараах жишээнд 2 тооны нийлбэр олох бодлогын хувьд байж болохуйц оролт, гаралтын форматыг үзүүлэв.

Жишээ оролт:	Жишээ гаралт:
4 (оролтын тоо)	
1 2	3
3 4	7
5 6	11
7 8	15

4. Бодлогын хувьсагчийн хязгаарлалтууд тодорхой, өгөгдсөн хязгаарлалтад тулсан дор хаяж нэг оролттой байх.
5. Стандарт оролт, гаралттай ажилладаг, зөв бодолтын C/C++ хэл дээрх програмтай байх
6. Бодлогын програмын код нь бүрэлдэхүүн хэсэг бүрийнхээ хувьд тухайн хэсгийнхээ агуулгыг илтгэсэн, ойлгомж бүхий тайлбаруудтай байх.
7. Эх код нь код бичих тодорхой стандартыг баримласан байх.
8. Тухайн бодлого нь урьд ямар нэг тэмцээнд дэвшигдэж байгаагүй байх.
9. Оролт, гаралтын файлуудыг програмын замаар үүсгэсэн байх.
10. Бодлогын тестийн форматыг тодорхой заах. Цэг, сул зай, мөрүүдийг анхаарах.
11. Бодлогоо битүүмжилсэн байдлаар Зохион байгуулах хороонд өгнө.
12. Бодлого сонгох комисс нь Бодлого сонгох шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж тэдгээр үзүүлэлтүүдээр бодлогуудыг дүгнэж бодлогуудыг сонгоно.

Хавсралт 6. Багийн гишүүнийг сонгох мод

Үндсэн шаардлага

Оролцох эсэхийг шийдэх

